

**Өлгий сумын ЗДТГ-ын 04-р сарын 26-с эхлэн 7 хоногт
хийсэн ажлын мэдээлэл**

2019-05-02

- Аймгийн засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/318, А/319 дугаар захирамж, Өлгий сумын Онцгой комиссын даргын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/116, А/117 дугаар захирамжуудын дагуу Өлгий сумын мэргэжлийн ангид ажиллаж байна.
- Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан сумын шуурхай штабыг байгуулан, хотын 6 чиглэлд гарах эргүүл постонд хүн хүч хувиарлан 24 цагийн байнгын жижүүр гарган ажиллуулж байна.
- Аймгийн Засаг даргаас баталсан “Эрүүл хүнс” сарын аяны хүрээнд Өлгий суманд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, 5 чиглэлд хувиар гаргасан болно.
- Багуудад ОНХС-н хөрөнгөөр баригдах авто зогсоолуудад газар сонголт хийж, зураг төслийг гаргаж бэлтгэсэн.
- 9-р багийн нутаг дэвсгэрт дэх хогийн хашаа татах газрын хэмжилт хийж, зураглал схем үйлдэж, төсөв хийлгэхээр холбогдох газарт баримт материалыг хүргүүлэв.
- Өлгий-Бугат сумын нутаг дэвсгэрээс хулгайгаар газар ухаж, хайраг ачиж буй иргэдийг илрүүлж үйл ажиллагааг таслан зогсоосон болно.
- 2,3-р багуудад шинээр тавигдах авто замын улаан шугамд орсон айл өрхүүдэд газар чөлөөлөх хугацаатай мэдэгдэх хуудас өглөө. Нийт 11 айл
- 12-р багийн иргэн худгийн ойролцоо хөрш айл нь муу усны цооног гаргасан тул гомдол гаргасан ба тухайн багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, байгаль хамгаалагч нар очиж газар дээр нь үзсэн муу усаа хаах болж шийдвэрлэсэн болно.
- Гудамж зам талбайн цэвэрлэгээ хийж 7тн хог ачиж хогийн цэгт хүргэв.
- Гудамж зам талбайг шөнийн гэрэлтүүлгээр хангаж, төв талбайн гэрэлтүүлгийн урсгал засваруудыг шөнийн гэрэлтүүлгээр хангаж байна.
- СӨХ-ны хогийг ачиж орон сууц орчмын цэвэрлэгээ хийж, хог шатаах явдалд хяналт тавьж ажиллаж байна
- Цэцэг тарих ажлын бэлтгэл ажлыг эхэлж цэцгийн мандлуудын шороог цэвэрлэж шарилжуудыг нь авч шороог услан цэцэг тарих ажлын бэлтгэл ажил хийж байна.
- Цэнгэлдэх хүрээлэнгийн талбайг услах ажил хийж байна.
- Хорио, цээрийн ажлаар постуудад гэр хүргэж барих, нүүрс, шатахуун хүргэх ажил хийв.

ӨЛГИЙ СУМЫН ЗДТГ